

Ажлын хуудас

Анги бүлэг

сурагчийн нэр

Хичээлийн сэдэв : Иргэний эрх зүй

1.Тохиолдол шинжилцгээе: Дараах тохиолдлыг уншаад даалгавруудыг гүйцэтгээрэй.

Оюутан Х шинэ жилийн үдэшлэгт ороход мөнгө хэрэгтэй байсан болохоор өөрийн танил үсчин Ж-тэй уулзан “надад 50000 төгрөг зээлдүүлээч, би баярын дараа чамд өөрийнхөө урт үсийг тайруулж оронд нь өгье” гэж ярилцан, тохиролцсон байна. Ж оюутан Х-ийн гоёмсог урт үсийг бусдад үс залгахдаа ашиглах хүсэлтэй байсан тул зөвшөөрөн, мөнгө өгсөн байна. Харин Х “баяр өнгөрсний дараа үсээ тайруулах хүсэлгүй болсон тул 6 сарын дараа зээлдүүлсэн мөнгийг чинь буцааж өгье” гэсэн байна. Х-ийн энэ байдалд дургүйцсэн Ж долоо хоногийн дотор тохиролцсон ёсоор үсээ тайрч, авчирч өгөхийг шаарджээ.

1.Иргэний эрх зүйн бүрдэл хэсгүүдийг зөв харгалзуулан холбоорой.

А. Иргэний эрх зүйн субъект

В.Иргэний эрх зүйн объект

С.Иргэний эрх зүйн агуулга

Үсээ өгөх тухай
тохиролцоо

Оюутан Х,
үсчин Ж

Үс

2. Оюутан Х эрх зүйн ямар чадамжтай вэ?

А.Бүрэн

В.бүрэн бус

С.заримдаг

Д.Чадамжгүй

3.Оюутан Х Үсээ заавал өгөх ёстой юу.

А.тийм

В.Үгүй

4.Иргэний эрх зүйн чадамжуудыг зөв байрлуулаарай.

1.0-7 настай

2.7-14 нас

3.14-18 нас

4.18-аас дээш нас

1.Бүрэн

2.Заримдаг

3.чадамжгүй

4.Бүрэн бус

5.Дээрх тохиолдол оюутан Х,үсчин Ж нарын хоорондох хэлцэл иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэлийн алинд хамаарах вэ?

А.Иргэний эрх зүйн харилцаа үүсэхэд чиглэсэн шүүхийн шийдвэр

В.Оюуны үнэт зүйл бүтээх

С.Агуулгын хувьд хуульд үл харшлах хэлцэл

Д.Үндэслэлгүйгээр эд юмс олж авах, эзэмших